

ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ХҮН АМЫН ЭРҮҮЛ МЭНД, ЭМНЭЛГИЙН ТУСЛАМЖ

ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТОВЧ МЭДЭЭЛЭЛ

/2021 оны 1 сарын байдлаар/

№	Үзүүлэлт	<u>БОЭТ</u>	<u>Сумдын эмнэлэг</u>	<u>Өрхийн эмнэлэг</u>	<u>Хувийн эмнэлэг</u>	<u>Цэргийн анги</u>	<u>Нийт дүн</u>
1	Нийт үзлэг	7648	8957	7536	5527	423	30091
2	Урьдчилан сэргийлэх үзлэг	1873	3009	3386	1693	381	10342
3	Идэвхтэй хяналтын үзлэг	919	2056	1854	478		5307
4	Бүртгэгдэж эмчлэгдсэн өвчлөл	3205	1969	707	1140	42	7063
5	Нийт төрөлт	103	35				138
6	Хэвтэн эмчлүүлэгчид	589	332		319	3	1243
7	Нас баралт	1	12	9			22

№	Үзүүлэлт	<u>2020.1</u>	<u>2021.1</u>	<u>Өөрчлөлт</u>
1	Нийт үзлэг	32347	30091	-2256
2	Урьдчилан сэргийлэх үзлэг	6635	10342	3707
3	Идэвхтэй хяналтын үзлэг	5253	5307	54
4	Бүртгэгдэж эмчлэгдсэн өвчлөл	10505	7063	-3442
5	Нийт төрөлт	153	138	-15
	Гэрийн төрөлт		1	1
6	Хэвтэн эмчлүүлэгчид	1634	1243	-391
7	Нас баралт	25	22	-3
	0-1 насны эндэгдэл	2	2	0
	1-5 насны эндэгдэл	1		-1
	Хурц халдварт өвчин	72	3	-69

Үзүүлэлт	хэмжих нэгж	2010.1 сар	2021.1 сар	өөрчлөлт
Нялхасын эндэгдэл	1000 амьд төрөлтөд	12.8	14.5	1.7
Үр хөндөлт	1000 амьд төрөлтөд	397.4	372.2	-25.2
Үүнээс охидын	хувь	6.4	15.6	9.2
Хурц халдварт өвчин	10000 хүн амд	10.3	0.4	-9.9
БЗДХ	10000 хүн амд	5.7	1.8	-3.9
Үүнээс өсвөр үе	хувь	5.0	23	18
Хүүхдийн хяналт /0-1 нас/	хувь	75.8	76.5	0.7
Хүүхдийн хяналт /1-5 нас/	хувь	37.4	44	6.6

I. ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭ

- Улсын болон хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагууд нийт 30091 хүнд үзлэг шинжилгээ хийсний 52%-д нь урьдчилан сэргийлэх болон идэвхтэй хяналт тандалтын үзлэг хийгдсэн байна.
- Ортой эмнэлгүүдэд нийт 1243 хүнийг 8091 ор хоногоор хэвтүүлэн эмчилсэн нь нэг хүн дунджаар 6.5 хоног хэвтэн эмчлүүлсэн байна.
- Түргэн тусламжийн 791 дуудлагад явж үйлчилсний 114/14.4%/ нь алсын дуудлага, 86/10.8% нь осол гэмтлийн яаралтай дуудлага байсан байна. Нийт дуудлагын 87.3% -д 0-20 минутны дотор гарч үйлчилсэн байна.
- Нийт эмийн сангууд 7342 жор хүлээн авч, 986 сая төгрөгний эм бараа борлуулалт хийсэн байна.
- ЭЭСангуудад нийт 1355 жор ирсний 58.8% /798/ нь ЭМДаатгалын, 4.2%/58/ мансууруулах сэтгэц нөлөөт эмийн, 36.8% /499/ нь энгийн эмийн жор байсан байна. Зайлшгүй шаардлагатай эмийн хангалт дундажаар 79.6% байна.

II. БҮРТГЭГДСЭН ӨВЧЛӨЛ, ЭНДЭГДЭЛ

- 1 сарын байдлаар 7063 халдварт бус өвчлөл шинээр бүртгэгдэж эмчлэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 3472 тохиолдлоор буурсан байна. Нийт өвчлөлийн 57,7% нь шинэ өвчлөл байна.
- 1 сарын байдлаар 126 хүн осол гэмтэлд өртсөний улмаас тусламж авсан ба осол гэмтлээр 4 хүн нас барсан нь өнгөрсөн оноос 2-р, өвчлөл 14 тохиолдлоор өссөн байна.
- Осол гэмтлээр нас барагсдын 50% /2/ нь зам тээврийн осол-/Нн-1,Өо-1,/ 50% /2/ нь бусад ослоор /Бо-1, Цц-1/ тус тус эндсэн байна.
- Осол гэмтлээр нас барагсад нь 50% /2/ эрэгтэй ба эмнэлгийн ямар нэг тусламж авч чадаагүй газар дээрээ нас барсан байна.
- Оны гарсаар 22 хүн нас барсан ба нийт нас барсан хүний 18,1% нь осол гэмтлээр, 22,7% нь хорт хавдраар, 4.5% нь зүрхний шигдээс, тархинд цус харвалт зэрэг сэргийлж болох эндэгдэлээр, 4.5% нь нярай үеийн эмгэгийн улмаас нас барсан байна. Нийт нас баралтын 2 нь эмнэлэгт, бусад нь гэртээ хээр гадаа нас барсан байна.
- Нялхсын эндэгдлийн 2 /Но-1,БООТ-1/ тохиолдол бүртгэгдсэн нь 1000 амьд төрөлтөд 14.5% байна.
- Нялхсын эндэгдэл 2020 онд 50% нь эрт нярайн эндэгдэл байсан бол 2021 онд мөн 50% нь эрт нярайн, 50% нь сараас дээш насны хүүхэд 1 байгаа ба хатгаагаар эндсэн байна
- БОЭТөвд 1 эндэгдэл тохиолдож задлан шинжилгээнд хамруулсан ба задлан шинжилгээний хувь 100% тай байна. Үндсэн оношийн зөрөө байхгүй.

III. ЭХ, ХҮҮХДИЙН ЭРҮҮЛ МЭНД

- Нийт 138 эх төрж 137 хүүхэд мэндэлсэн нь өнгөрсөн онтой харьцуулахад 15 төрөлтөөр хүн амын төрөлт буурсан байна. Нийт төрсөн хүүхдийн хүйсийн харьцаа 1,1:1 байгаа ба эрэгтэй хүйс давамгайлж байна.
- Нийт төрөлтийн 8 /5,7%/ охидын төрөлт эзэлж байгаа нь анхаарал татаж байгаа үзүүлэлт байна./Шб-3,Өо-2, Эх-3/.
- 1 сарын байдлаар 51 эх үр хөндүүлж 1000 амьд төрөлтөд 372.2 байгаа нь өнгөрсөн оноос 25.2-р буурсан үзүүлэлт байна.Өсвөр насны охидын үр хөндөлт-8/15.6%/ Бд-1,Бу-1,Гт-1,Цо-2,Цц-1,Өо-1,Эх-1/ байна.
- Үр хөндөлт 1000 амьд төрөлтөд 25,2-р буурсан боловч , охидын үр хөндөлт 9,2-р нэмэгдсэн байна.
- 1 сарын байдлаар сард дундажаар 4244 хүүхдийг идэвхтэй хянаж, хооллолт өсөлт хөгжилтийн байдлыг үнэлэн зөвлөгөө дэмжлэг үзүүлсэн нь хяналтад хамрагдвал зохих хүүхдийн 64,5% эзэлж байгаа нь хангалтгүй байна. Хяналтанд хамрагдсан хүүхдүүдээс 1 хүүхэд жингийн алдагдалтай байгаа нь нийт хүүхдийн 0,01%-г эзэлж байгаа ба 12 хүүхэд туранхай, 7 хүүхэд өсөлт хоцрогдолтой байна.
- 0-1 насны хүүхдийн хяналт 0,7-р, 1-5 хүртэлх насны хүүхдийн хяналт 6,6-р тус тус өссөн ба хяналтын хувь нэмэгдэхэд тураалын тархалт нэмэгдэх хандлагатайг харуулж байна.

IV. ХАЛДВАРТ ӨВЧИН

- Он гараад 22 халдварт өвчин бүртгэж эмчилсэн нь өнгөрсөн оноос 93 тохиолдлоор буурсан байна. Нийт халдварт өвчний 4,5%-г салхинцэцэг,4,5% сүрьеэ, 4,5%-г гар хөл амны өвчин,4,5% цусан суулга,59%-г БЗДХ өвчин тус тус эзэлж байна.
- БЗДХ-н 7,7% нь жирэмсний үзлэгээс,7,6% нь урьдчилан сэргийлэх үзлэгээр, 46,1% нь өвчний учир амбулатороор, 38,4% нь тандалтын үзлэгээс илэрсэн байна.

Мэдээлэл бэлтгэсэн: ЭМГ-н статистикч Б Мидэрсүрэн , Д. Гантогтох